

Эдийн засаг, хөгжлийн яамны
Төрийн нарийн бичгийн даргын 2026 оны
01 дугаар сарын 13-ний өдрийн 12 дугаар
тушаалын 12 дугаар хавсралт



АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТ

А. ТАНИЛЦУУЛГА

1. Гэрээний дугаар:	2. Төсөл хэрэгжүүлэгч байгууллага: Эдийн засаг, хөгжлийн яам
3. Орон тоо, албан тушаал: Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн Мал аж ахуйн асуудал хариуцсан шинжээч	
4. Ажлын байрны шууд харьяалах удирдах албан тушаалын нэр: Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн Хөдөө аж ахуйн асуудал хариуцсан дэд зохицуулагч	

Б.ЧИГ ҮҮРЭГ

1. Ажлын байрны үндсэн зорилго:	Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн төслийн хүрээнд хүрээнд мал аж ахуй, бэлчээрийн менежменттэй холбоотой бодлого, арга хэмжээг хэрэгжүүлэхэд малын эрүүл мэндийг сайжруулах замаар ашиг шимийг нэмэгдүүлэх, байгаль орчинд ээлттэй үйлдвэрлэл туршлагыг нэвтрүүлэх, нэмүү өртгийн оновчтой сүлжээг бий болгох, мал аж ахуйн тогтвортой менежмент, агробизнесийг хөгжүүлэн ажиллах.		
2. Ажлын байрны дэд зорилтууд:	1. Төслийг Монгол Улсын Засгийн газар болон Хөгжлийн түншүүдийн бодлого, удирдамж, зааварт нийцүүлэн хэрэгжүүлэх; 2. Төслийн мал аж ахуй, бэлчээрийн менежментийн бүрэлдэхүүний хүрээнд зорилтот аймаг, сумдад малын эрүүл мэндийг сайжруулах замаар ашиг шимийг нэмэгдүүлэх; 3. Төслийн мал аж ахуй, бэлчээрийн менежментийн бүрэлдэхүүний хүрээнд зорилтот аймаг, сумдад байгаль орчинд ээлттэй үйлдвэрлэл туршлагыг нэвтрүүлэх, нэмүү өртгийн оновчтой сүлжээг бий болгох, мал аж ахуйн тогтвортой менежмент, агро-бизнесийн загварыг хэвшүүлэх;		
3. Ажлын байрны үндсэн үйл ажиллагаа:	Хугацаа/ хуваарь	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	
1. Төслийн зөвлөхүүд, төрийн болон орон нутгийн байгууллагууд, төслийн удирдах хороо, Хөгжлийн түншүүд болон бусад хандивлагч, оролцогч талуудын хоорондын уялдаа холбоог сайжруулахын тулд тогтмол мэдээ мэдээллээр ханган ажиллах, тайлагнах	Төсөл хэрэгжих хугацаанд	Үйл ажиллагааны явцын тайлан, сар, улирал, жилийн тайлан	

2. Төслийн бүх үе шатны төлөвлөлт, хэрэгжилтийн үйл явцад хариуцсан ажлуудаа тогтвортой хэрэгжүүлэх. 3. СЯ, ЭЗХЯ, ХХААХҮЯ болон Хөгжлийн түншүүдийн шаардлагад нийцсэн тайлан, мэдээллийг цаг тухайд нь бэлтгэж хүргүүлэх. 4. Сургалт, зөвлөгөөн, чадавх бэхжүүлэх үйл ажиллагаа, танилцах аялал зохион байгуулж, оролцогчдод ногоон хөгжлийн шилдэг туршлагыг түгээн танилцуулах 5. Төслийн хэрэгжилттэй холбоотой Эдийн засаг, хөгжлийн яамны Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн төслийн зохицуулагч болон дэд зохицуулагчаас өгсөн бусад үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх. 6. Зорилтот аймаг, сумдын малын эрүүл мэндийн талаар болон холбогдох мэдээ, мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийх. 7. Малын өвчнөөс урьдчилан сэргийлэх, тандах, тэмцэх стратеги төлөвлөгөө боловсруулах. 8. Мал эмнэлгийн лабораторийн оношилгоо, дэвшилтэт техник хэрэгслээр шинэчлэх замаар орон нутгийн мал эмнэлэг, үржлийн нэгжийг бэхжүүлэх. 9. Мал эмнэлэг, үржил селекц, сайн дурын ажилтнуудын чиглэлээр сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах, оролцох. 10. Малын гаралтай бүтээгдэхүүний мөшгөх тогтолцоо, гэрчилгээжүүлэх ажлын хүрээнд программ хангамж, тоног төхөөрөмжийн хэрэгцээг тодорхойлох, уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах, оролцох. 11. Хамгаалагдсан аж ахуй (хорио, цээрийн байгууламж) байгуулах судалгааг хийж танилцуулах. 12. Мал эмнэлгийн лаборатори, хорио цээрийн тоног төхөөрөмжийн зорилтот аймаг, сумдын хэрэгцээ шаардлагын судалгаа хийж танилцуулах, дэмжлэг үзүүлэх 13. Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний зах зээлийн чиг хандлага, үнэ цэний сүлжээний талаар судлан, дүн шинжилгээ хийх		
--	--	--

14. Аймаг, сумдын агро-бизнесийг хөгжүүлэх төлөвлөгөөг Малчдын байгууллага, баталгаажуулалтын мэргэжилтэнтэй хамтран боловсруулах.		
15. Аймаг, сумдын агро-бизнесийг хөгжүүлэх төлөвлөгөөг малчид, БАХ, хоршоодод танилцуулах, өртгийн сүлжээг хөгжүүлэх.		
16. Олон нийтэд суурилсан хөрөнгө оруулалтын төслийг Малчдын байгууллага, баталгаажуулалтын мэргэжилтэнтэй хамтран боловсруулах		
17. Төслийн арга зүйг Малчдын байгууллага, баталгаажуулалтын мэргэжилтэнтэй хамтран малчдад заах, зааварчлах, төслүүдийг эцэслэн боловсруулах.		
Тайлбар: Ажил гүйцэтгэх хугацаа, хуваарийг жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөгөөр тодорхойлно.		

В. АЖЛЫН БАЙРАНД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

1.Ажлын байранд тавигдах шаардлага	1.1.Ерөнхий шаардлага	Үзүүлэлт	Чухал шаардлагатай	Шаардлагатай
		Боловсрол	Магистр болон түүнээс дээш зэрэгтэй байх	Зөвлөх зэрэгтэй бол давуу тал болно.
		Мэргэжил	Хөдөө аж ахуйн шинжлэх ухаан /0811/, эсвэл холбогдох чиглэлээр бакалавр	
		Туршлага	хөдөө аж ахуй, мал эмнэлэг, малзүйчийн чиглэлээр 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай; харилцааны болон хүмүүстэй харилцах чадвар сайтай байх; асуудал шийдвэрлэх ур чадвар, хөдөө орон нутгийн орчинд ажиллах дасан зохицох чадвар; хөдөө аж ахуйн төсөл, санаачилгын үр дүнтэй хэрэгжилтийг	Хөдөө аж ахуйн салбарт тэр дундаа мал эмнэлэг, мал үржлийн чиглэлээр ажилласан.

			хангахын тулд төслийн талбайд ажиллахад тууштай байх;	
		Ур чадвар	Англи хэлний аман болон бичгийн харилцааны өндөр ур чадвартай байх	
	1.2.Тусгай шаардлага	-	Орон нутагт томилолтоор ажиллах боломжтой байх.	

Г. АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТЫГ БАТАЛСАН:

ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ	
Шийдвэрийн огноо:	2026.01.13
Дугаар:	A/04
(тамга/ тэмдэг)	
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА	(И.БАТХҮҮ)
2026 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр	

